



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

┌ Үлгэрчилсэн хөтөлбөр шинэчлэн ┐  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т даалгасугай.

3. Үлгэрчилсэн хөтөлбөрт суурилсан төлөвлөгөөг жил бүр суралцагчдын оролцоотой боловсруулан баталж, үр дүнтэй хэрэгжүүлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Үлгэрчилсэн хөтөлбөр батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/288 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0085

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2024 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн  
А/26 дугаар тушаалын хавсралт

## ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

XXI зууны суралцагч нь өмнөх үеийн суралцагчдаас хэл, соёлын олон янзын сонирхол, сурах хэрэгцээ болон өөрсдийгөө хувь хүн гэж үзэх мэдрэмж, үл давтагдах байдал, дижитал эринд амьдарч байгаагаараа ялгаатай.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч хэл, соёл, нийгэм эдийн засаг, боловсролын түвшин ямар байгаагаас үл хамааран мэдээллийг тогтмол, шуурхай авах боломжтой дижитал, хөдөлгөөнт, холбогдсон нийгэмд өсөж байна.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс 2021 онд хийсэн “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдал”-ын судалгаагаар сургуулийн хэмжээнд төлөвлөсөн ажлын 47.0 хувь нь хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хамгаалах, 17.6 хувь нь эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж хүүхдийн хөгжлийг дэмжих, 35.2 хувь нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжин туслах, зөвлөн туслахад чиглэсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль болон дотуур байрны орчинд суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулж, сургууль бүр өөрийн онцлог, нөөцөд суурилан тогтвортой хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

### Хоёр. Зорилго, тэргүүлэх чиглэл, эзэмшүүлэх чадвар

2.1. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны зорилго нь суралцагчийн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгахад дэмжин туслах, мэдлэгээ хэрэглэх чадвар болон хувь хүний хөгжлийг дэмжих, авьяас, сонирхлыг хөгжүүлэхэд чиглэнэ.

2.2. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, үр дүнд суурилсан, суралцагч бүрийн хувийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, хөгжлийн ялгаатай байдлыг харгалзсан, авьяас сонирхол, ур чадварыг хөгжүүлэх, дэмжих, хамтран суралцахад чиглэсэн, тэгш хамрагдах боломж олгосон, ялгаварлан гадуурхалтаас ангид, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурласан, олон хувилбартай, нээлттэй, хяналттай байх зарчим баримтална.

2.3. Суралцагчийн хичээлээр эзэмшсэн XXI зууны иргэнд шаардагдах зөөлөн ур чадвар буюу өөрийгөө таньж мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах, цагийг зөв төлөвлөн зохицуулж сурах, бүтээлч, санаачилгатай байх, багаар хамтран ажиллах, бусдыг сонсох, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй харилцах, хүлээцтэй байх, хариуцлагатай, ёс зүйтэй, шүүн тунгаах сэтгэлгээтэй болон асуудал шийдвэрлэх, аливаа бэрхшээлийг даван туулах, дасан зохицох чадвартай байх зэргийг хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэхэд дэмжин тусална.



## 2.4. Суралцагчдад дараах ур чадварыг эзэмшүүлнэ.

**Бага ангид:** Эрүүл байхын төлөө дасгал хөдөлгөөн хийхийн чухлыг ойлгох, эрүүл зөв амьдралын дадал хэвшилтэй болох, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, бусдыг хүндэтгэх

**Дунд ангид:** Өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө санаа тавьдаг, сэтгэл хөдлөлөө удирддаг, бусдын санаа бодлыг сонсох, эргэцүүлэх, сурах хэрэгцээгээ ухамсарлах, технологийн дэвшлийг үр дүнтэй, хариуцлагатай ашиглах, өөрийгөө болон хувийн мэдээллээ хамгаалахад суралцах, аливаа эрсдэлтэй зан үйл, хорт зуршлаас татгалзах, даван туулах

**Ахлах ангид:** Дасгал хөдөлгөөнөөр дамжуулан тэсвэр тэвчээртэй, өрөвдөх сэтгэлтэй, идэвхтэй оролцоотой байх чадвар, дадлуудыг эзэмших, нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах, багш, найз нөхөд, ард иргэдийн өмнө хариуцлага хүлээх чадвартай болох

## 2.5. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааг дараах тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ:

| Тэргүүлэх чиглэл                                                                                                          | Үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, үүрэг оролцоог гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хэрэгжүүлэхэд хамтрах үйл ажиллагаа | 1.1. Хүүхдийн хөгжил, төлөвшилд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа;<br>1.2. Хүүхэд хүмүүжүүлэх гэр бүлийн уламжлалт соёл, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлан тэднийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа;<br>1.3.Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй, шүдний цоорлоос сэргийлэх, хоол хүнсний зөв хэрэглээнд сургах сургалт, үйл ажиллагаа;<br>1.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр дамжуулан шударга иргэн төлөвшүүлэх, шударга ёсны боловсрол, мэдлэг олгох үйл ажиллагаа; |
| 2. Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа:           | 2.1.Амьдралын аюулгүй байдлыг эрхэмлэдэг, хорт зуршил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;<br>2.2.Хүүхдийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа;<br>2.3.Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, үйл ажиллагаа;<br>2.4.Замын хөдөлгөөнд зөв, соёлтой оролцох, дадал төлөвшүүлэх, осол, гэмтэл, эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа;<br>2.5. Хүүхдийг идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт сургах, эрүүл хоол, хүнс хэрэглэхийн ач холбогдлыг таниулахад чиглэсэн, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа;      |
| 3. Бие бялдар, авьяас чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа                                                                      | 3.1. Шинжлэх ухаан-танин мэдэхүй, зохион бүтээх сэтгэлгээ, чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа;<br>3.2. Уламжлалт өв соёл, соёлын биет болон биет бус өвийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагаа;<br>3.3. Өөрийн орны болон дэлхийн урлагийн бүтээлийг сурталчлах, хүүхдэд соёлын боловсрол олгох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, дэмжин хөгжүүлэх үйл ажиллагаа;<br>3.4.Хувь хүний хөгжил, иргэн болж төлөвшихөд шаардлагатай ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа                                                                                                    |
| 4. Мэдээллийн технологийн ёс                                                                                              | 4.1. Цахим орчны зохистой, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх, цахим орчныг хүүхдийн хөгжил, шинэ мэдлэг бий болгоход ашиглах чадвар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |

|                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|--------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| зүйтэй хэрэглээг дэмжих үйл ажиллагаа                                    | <p>төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа</p> <p>4.2. Цахим орчинд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт, хүмүүжилд сөргөөр нөлөөлж болохуйц мэдээллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, цахим орчинд эрсдэлт нөхцөлд орсон тохиолдолд авах арга хэмжээний талаар мэдлэг олгох үйл ажиллагаа</p> <p>4.3. Цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хувийн мэдээллээ хамгаалах, бусдын эрхэд хүндэтгэлтэй хандах чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| 5. Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа | <p>5.1. Суралцагчдын өөрсдийн санаачилсан нийгэмд тустай үйл ажиллагаанд бүтээлчээр оролцоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа;</p> <p>5.2. Хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагаа;</p> <p>5.3. Суралцагчдын хэрэгцээ, сонирхол, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа;</p> <p>5.4. Орон нутгийн байгууллага, иргэдтэй хамтарч нутгийн онцлогтой аж ахуй эрхлэх арга туршлагатай танилцаж, орон нутгаа хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад чиглэсэн үйл ажиллагаа;</p> <p>5.5. Сайн үйл хийх, хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах, оролцох замаар байгаль орчны нөхөн сэргээлт болон нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулахад чиглэсэн үйл ажиллагаа;</p>                                                                                                                                                        |
| 6. Хувь хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн байх ур чадвар эзэмшүүлэх   | <p>6.1. Суралцагчдад шударга байдлыг төлөвшүүлэх, ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгох, сургууль, нийгмийн амьдралын хүрээнд тулгамдаж буй асуудлыг дэвшүүлж, шийдлийн хувилбарыг санал болгох замаар бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, энтрепренершип боловсрол олгоход чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагаа;</p> <p>6.2. Суралцагчдад хувь хүний хөгжил, нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварт суралцахад дэмжлэг үзүүлэх хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагаа;</p> <p>6.3. Суралцагчдад бусдыг хүндлэх, хүмүүнлэг, энэрэнгүй, зөв зан чанарыг бүрэлдүүлэх, хувийн болон гэр бүл, улс нийгэмд хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа;</p> <p>6.4. Суралцагчдын дунд номыг бүтээлчээр унших хөдөлгөөн өрнүүлж, ном зохиох, хэвлэн нийтлэх, гэрийн болон явуулын номын сан ажиллуулах зэрэг үйл ажиллагааг иргэд, төр, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа;</p> |
| 7. Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих                          | <p>7.1. Хүүхдэд эх оронч хүмүүжил олгох үйл ажиллагаа;</p> <p>7.2. Эх орныхоо үнэт зүйлсийг танин мэдэх, соёл, уламжлал, ёс заншил, хадгалж явах иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа;</p> <p>7.3. Суралцагчдад суралцах чиглэл, мэргэжлээ зөв сонгох, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход туслах, дэмжлэг үзүүлэх зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ;</p> <p>7.4. Хөдөлмөрийг хүндэтгэх зан чанарт сургахад чиглэсэн үйл ажиллагаа;</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 8. Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх                             | <p>8.1. Хүүхдэд байгаль орчин, эх орон, газар нутгаа хайрлан хамгаалах хандлага төлөвшүүлэх үйл ажиллагаа;</p> <p>8.2. Байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх үйл ажиллагаа;</p> <p>8.2. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг суралцагчдад таниулах, тогтвортой хөгжлийн зорилгод хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа;</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |



### **Гурав. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэлбэр, хэрэгжүүлэх арга зүй**

3.1. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааг суралцагчийн сайн дурын үндсэн дээр тэдний сонирхол, хэрэгцээ, хүний нөөц, багшийн ур чадвар, орон нутгийн онцлог зэргийг харгалзан сургууль, нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагыг түшиглэн суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоотой зохион байгуулна.

3.2. Энэ хөтөлбөрийн 2.5-д заасан тэргүүлэх чиглэлийг суралцагчийн авьяас сонирхлыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ болон сургалтын хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадварыг дэмжсэн бусад үйл ажиллагаа, төсөлт ажил гэсэн үндсэн 3 хүрээг хамарч зохион байгуулна.

3.3. Дотуур байранд амьдарч байгаа суралцагчид зориулан тэдний суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааг суралцагчдын оролцоо, хэрэгцээнд суурилан зохион байгуулна.

3.4. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт нь суралцагчийн насны онцлогоос хамаарч секц, дугуйлан, урлаг, биеийн тамир, спорт болон бусад клуб, ур чадвар хөгжүүлэх, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжих хөтөлбөр, зөвлөгөө өгөх, дэмжин туслах үйлчилгээ үзүүлэх хэлбэртэй байна. Тухайлбал,

3.4.1. секц, дугуйлан нь дуу, хөгжим, бүжиг, баримал, уран зураг болон гар бөмбөг, сагсан бөмбөг, бөх, байт сур, сур харваа, хөнгөн атлетик болон усанд сэлэлт зэрэг урлаг, спортын төрлөөр авьяасыг нээн хөгжүүлэх;

3.4.2. клуб нь номын болон хувцас, хоолны технологи, шатар, илтгэх урлагт сурах, зохион бүтээх гэх мэт авьяас хөгжүүлэх, мэтгэлцээн, шударга ёсны болон цахим орчин, байгаль экологи, хүмүүнлэгийн сайн дурын үйл ажиллагаагаар хувь хүний нийгэмшихүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх;

3.4.3. хүүхдийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшлийг дэмжих болон сургууль, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах хөгжлийн нэмэлт хөтөлбөр, төсөлт ажил гүйцэтгэх.

3.5. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааг ганцаарчилсан, анги дагнасан, холимог анги, бүлгийн болон сургууль дундын хэлбэрээр зохион байгуулж болно.

3.5.1. сургууль дундын хэлбэрээр зохион байгуулах секц, дугуйланг орон нутгийн онцлог, багшийн ур чадвар, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний нөөцийг тус тус харгалзан сургуулийн болон мэргэжлийн байгууллагын байр, танхим, спорт, соёл үйлчилгээний газар, сургалт-туршилтын талбайд хичээллүүлж болно.

3.6. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд боловсролын түвшинээс хамаарч бага ангид тоглоом, шинжлэн судлах арга барил болон орчинд суурилсан арга зүй, дунд ангид асуудалд суурилсан, шинжлэн судлах, оролцоо болон орчинд суурилсан арга зүй; ахлах ангид асуудалд суурилсан, төсөлд суурилсан болон шинжлэн судлах, хамтран суралцах арга зүйг тус тус ашиглана.

### **Дөрөв. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ**

4.1. Сургууль нь суралцагчийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг хангах, өсвөр үеийнхний оролцоо, хамгааллын асуудлыг цогц байдлаар шийдсэн, хүүхдэд ээлтэй танхимын болон танхим бус сургалтын орчныг бүрдүүлсэн байна.

4.1.1. Танхимын орчинд: багаар болон бүлгээр уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах; урлаг, спорт, хурлын заал, анги танхим дахь үйл ажиллагаа, илтгэл тавих, тайлан бичих, хамгаалах.

4.1.2. Танхимын бус орчинд: орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцах; сургууль, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтын ажиллагаанд тулгуурласан үйл ажиллагаа зохион байгуулах, хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчидтэй хамтарсан төсөлт ажил гүйцэтгэх, судалгаа хийх; бүтээлч санал, санаачилга бүхий сайн үйлсийн аян өрнүүлэх; зайн сургалтын хэлбэрийг хөгжүүлэх.

4.2. Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үр дүнд суралцагчдад гарсан ахиц өөрчлөлтийг сэтгэл ханамжийн асуулгаар үнэлнэ.

4.3. Сэтгэл ханамжийн асуулга, судалгааг хичээлийн жилийн хоёрдугаар хагас болон хичээлийн жилийн төгсгөлд тус тус авч, үнэлгээ дүгнэлт хийнэ.

---000---



**ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР /Загвар/**

| Чиглэл                                                                                                                                                                                                       |               | Бага анги                                                                                                                                                         | Дунд анги                                                                                                                                                                                                                                                                               | Ахлах анги                                                                                                                                                                                                                                                    | Дотуур байр                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                      |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Зохион байгуулагч: Нийгмийн ажилтан "1", сэтгэл зүйч "2", эмч "3", АУБ "4", дотуур байрны багш "5", мэргэжлийн багш "6", номын санч "7", сурагчдын зөвлөл "8", эцэг эх, асран хамгаалагч "9", хоол зүйч "10" |               |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                      |
| Сургалт, үйл ажиллагааны хэлбэр: танхим, танхимын бус хосолсон сургалт                                                                                                                                       |               |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                      |
| Ур чадвар                                                                                                                                                                                                    |               | Эрүүл байхын төлөө дасгал хөдөлгөөн хийхийн чухлыг ойлгох, эрүүл зөв амьдралын дадал хэвшилтэй болох, өөрийн, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, бусдыг хүндэтгэх | Өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө санаа тавьдаг, бусдын санал бодлыг сонсох, эргэцүүлэх, хэрэгцээгээ ухамсарлах, технологийн дэвшлийг үр дүнтэй, хариуцлагатай ашиглах, хувийн мэдээллээ хамгаалах, аливаа эрсдэлтэй зан үйл, хорт зуршлаас татгалзах, даван туулах | Дасгал хөдөлгөөнөөр дамжуулан тэсвэр тэвчээртэй, өрөвдөх сэтгэлтэй, идэвхтэй оролцоотой байх чадвар, дадлуудыг эзэмших, нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах, багш, найз нөхөд, ард иргэдийн өмнө хариуцлага хүлээх чадвартай болох | Дасгал хөдөлгөөн хийхийн чухлыг ойлгох, эрүүл зөв амьдралын дадал хэвшилтэй болох, өөрийн, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, бусдыг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх, бусдын санал бодлыг сонсох, эргэцүүлэх, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах |                                                                                                                      |
|                                                                                                                                                                                                              |               |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                      |
| Сургалт                                                                                                                                                                                                      | Заавал судлах | Эрүүл мэндийг дэмжих                                                                                                                                              | Шүд, гараа угаах ойлголтыг зурагт хуудас, үзүүлэн, видео, дуугаар үзүүлэх                                                                                                                                                                                                               | Эрүүл мэнд өдөр тутмын дэг, соёл, эрүүл аюулгүй байдлын талаарх ойлголттой болох                                                                                                                                                                              | Эрүүл мэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар ойлголттой болгох                                                                                                                                                                                       | Хувийн ариун цэвэр сахиx, шүд, гар угаах усанд орох, хувцас угаах дадалтай болох                                     |
|                                                                                                                                                                                                              |               |                                                                                                                                                                   | Эрүүл хоол буюу ногоон хүнсний тухай ойлголттой болгох                                                                                                                                                                                                                                  | Эрүүл хүн гэж ямар хүнийг хэлэх талаарх ойлголттой болгох                                                                                                                                                                                                     | Эрүүл байснаар өөртөө болон нийгэмд гарах үр дүнгийн талаарх ойлголттой болгох                                                                                                                                                                         | Хооллолт ба эрүүл байх, дасгал, хөдөлгөөний ач тусын талаарх ойлголттой болгох                                       |
|                                                                                                                                                                                                              |               | Хариуцах албан хаагч                                                                                                                                              | 1,"3","4","7","9",10                                                                                                                                                                                                                                                                    | "1","2","3","4","9"                                                                                                                                                                                                                                           | "1","2","3","4","9"                                                                                                                                                                                                                                    | "3","5","9","10"                                                                                                     |
|                                                                                                                                                                                                              |               | Бүтээлч үйл ажиллагааг дэмжих                                                                                                                                     | Багшийн чиглүүлэгтэй суралцах, унших, бичих будах үйлийг дэмжих, номтой танилцуулах,                                                                                                                                                                                                    | Ном унших арга барилаар дамжуулан зохион бүтээх, хийсвэрлэн сэтгэх үйлийг сайжруулах, дэмжих                                                                                                                                                                  | Бие дааж ажиллах, түүгээр дамжуулан бүтээлчээр сэтгэх үйлийг дэмжих, номын аян явуулах                                                                                                                                                                 | Бусдаас суралцах, хамтран суралцах бие биедээ туслах, юмханаар юм хийх чадварыг дэмжих, явуулын номын сан ажиллуулах |
|                                                                                                                                                                                                              |               | Суралцагч хоорондын харилцааг дэмжих                                                                                                                              | Өөрийгөө болон бусдыг хүндэтгэх соёлд суралцах                                                                                                                                                                                                                                          | Охид хөвгүүдэд жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх                                                                                                                                                                 | Хүчирхийлэл, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх                                                                                                                                                                                          | Дасан зохицож амьдрах чадвартай, амьдралын зөв дадал хэвшилтэй болох                                                 |
|                                                                                                                                                                                                              |               | Эрүүл, аюулгүй амьдрах ухаанд сургах, эрсдэлээс                                                                                                                   | Зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх                                                                                                                                                                                                                                         | Нийгмийн орчны аюулгүй байдал, хорт зуршил, эрсдэлд өртөхөөс сэргийлэх                                                                                                                                                                                        | Урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, шийдвэр гаргах чадвартай болгох                                                                                                                                                                               | Тохиолдож болзошгүй аюул, ослын тосоолөлтэй болгох                                                                   |

|                      |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                          |                                                                                                                                                                      |                                                |                                                                                                                                               |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                      |                                                                                                                     | урьдчилан сэргийлэх                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                          |                                                                                                                                                                      |                                                |                                                                                                                                               |
|                      | Хариуцах албан хаагч                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | "1","3", "4","7" "9"                                                                                                     | 1","2","3", "4", "7",9                                                                                                                                               | "1","2","3", "4","7","9"                       | "3", "5", "7","9"                                                                                                                             |
|                      | Сонгон судлах                                                                                                       | Нийгэмшил, танин мэдэхүйн чиглэлээр                                                                                                                                                                                                                                                                                                           | Нийгэмшлийн хөгжлийг дэмжих /хувь хүний хөгжил, илтгэх урлаг, өөрийгөө нээх, зөөлөн ур чадвар                            |                                                                                                                                                                      |                                                | Дотуур байрны багш өөрийн мэргэжил, сонирхол, ур чадварт тулгуурлан зохион байгуулах                                                          |
|                      |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Шинжлэх ухаан, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих                                                                            |                                                                                                                                                                      |                                                |                                                                                                                                               |
|                      |                                                                                                                     | Хувь хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн байх ур чадвар эзэмшүүлэх                                                                                                                                                                                                                                                                           | Дэлхийн иргэн байх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох                                                                  |                                                                                                                                                                      | Мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиг баримжаа |                                                                                                                                               |
| Хариуцах албан хаагч |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | "1","3", "4", "9"                                                                                                        | 1","2","3", "4", "6",9                                                                                                                                               | "1","2","3", "4","6","9"                       | "5", "9"                                                                                                                                      |
| Үйл ажиллагаа        | секц, дугуйлан, клуб, төсөлт ажил мэтгэлцээн хүмүүнлэг, сайн дурын үйл ажиллагаа хэлэлцүүлэг хөгжлийн хөтөлбөр, аян |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Тоглоом, жүжигчилсэн тоглолт, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, эх орныхоо үзэсгэлэнт газраар аялах                      | Багш суралцагчдын сонирхол, хэрэгцээ, ур чадварт тулгуурлан чиглүүлэн хөгжүүлэх, эх орны газар нутгаа хайрлах,бахархах, хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгуулах,            |                                                | Дотуур байрны онцлогт тулгуурлан секц, дугуйлан, төсөл хэрэгжүүлэх, орчноо тохижуулах, өөрийн төрөлх нутаг усаа бусдад танилцуулах аян зохиох |
| Хариуцах албан хаагч |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 1","2","4","8","6",7                                                                                                     | 1","2", "4", 8","6","7                                                                                                                                               | "1","2","4","8","6","7"                        | "1","2","5","8","6","7"                                                                                                                       |
| Сургуулийн онцлог    |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                          |                                                                                                                                                                      |                                                |                                                                                                                                               |
| Сургуулийн онцлог    | Суралцагч                                                                                                           | Орчин хэрэглэгдэхүйн давуу талаа ашиглах                                                                                                                                                                                                                                                                                                      | Аялал, экскурс хийх                                                                                                      | Суралцагчдын авьяасаа хөгжүүлж, харилцан суралцаж буй байдлыг бүтээлийн үзэсгэлэн гаргах, тайлан тоглолт хийх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх |                                                |                                                                                                                                               |
|                      | Эцэг эх, гэр бүл                                                                                                    | Гэр бүл, сургуулийн хоорондын харилцааг бэхжүүлэх                                                                                                                                                                                                                                                                                             | Эцэг эх, асран хамгаалагчдын тусламжтайгаар суралцагчдын суралцах арга барилыг эзэмшүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах | Эцэг эх, асран хамгаалагчдад сургалт , мэдээллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах                                                                            | Суралцагчдын мэргэжил сонголтод чиглүүлэх      | Дотуур байранд дээрэлхэлт, хараа хяналтгүй цахим хэрэглээг хязгаарлах талаар хамтран ажиллах                                                  |
|                      | Ээлтэй орчин бүрдүүлэх                                                                                              | Хүүхдийн амьдрах, суралцах аюулгүй орчин, цахим орчны зохистой, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшилд дэмжлэг үзүүлэх хэрэгсэл болгон ашиглах,зүй бус үйлдлээс өөрийгөө хамгаалах, чадвар төлөвшүүлэхэд чиглэсэн орчинг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид болон бусад оролцогч талуудтай хамтран бүрдүүлэх |                                                                                                                          |                                                                                                                                                                      |                                                |                                                                                                                                               |
| Хариуцах албан хаагч |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | "1", "4","8", "9"                                                                                                        | "1", "4","8", "9"                                                                                                                                                    | "1", "4","5","8", "9"                          | "1", "4","5","8", "9"                                                                                                                         |